



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 271

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.б дэх заалт, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төвд барьж, ашиглалтад оруулсан нийт 4,200,000,000.0 (дөрвөн тэрбум хоёр зуун сая) төгрөгийн үнэ бүхий "Шинэ мөрөн худалдааны төв"-ийн барилгыг Хөвсгөл аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. "Шинэ мөрөн худалдааны төв"-ийн барилгыг худалдаа үйлчилгээнээс өөр зориулалтаар ашиглахгүй байхыг Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

3. Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Болдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. "Шинэ мөрөн худалдааны төв"-ийн барилгыг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комисс

ын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

3.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д оруулах ажлыг зохион байгуулах;

3.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001909